



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction



Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр

Аймгийн хөгжлийн чиг баримжаа

Монгол улс

Барилга, хот байгууллатын яам


Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Азийн хөгжлийн банк & Ядуурлыг бууруулах Японы Сан

АХБ ТА 9666-MON төслийн санхүүжилтээр бэлтгэв.



Аймгийн хөгжлийн чиг баримжаа
Увс аймгийн атлас



Энэхүү атлас нь Аймгийн хөгжлийн чиг баримжаа (АХЧБ) баримт бичгийн хураангуй хувилбар болно.

Монгол улс
Барилга, хот байгууллагын яам
Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сан
АХБ ТА 9666-MON төслийн санхүүжилтээр бэлтгэв.

Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр

Увс аймгийн Атлас

2022 оны 2 дугаар сар


Увс аймгийн хөгжлийн чиг баримжаа (АХЧБ)


groupe huit
Développement urbain

 MAD URBAN  naomis
Systèmes d'information

Газарзүй

ТАНИХ ТЭМДЭГ



Тусгай хамгаалалттай газар нутаг .

Дархан цаазат газар

- ① Увс нуур
- ② Цагаан Шивээт Уул
- ③ Түргэн Уул
- ④ Алтан элс

Байгалийн нөөц газар

- ⑤ Тэсийн Гол
- ⑥ Алтан Хөхий
- ⑦ Булган Хангай Уул

Байгалийн цогцолборт газар

- ⑧ Хяргас Нуур
- ⑨ Дэвэлийн Арал
- ⑩ Хан Хөхийн Нуруу

Газрын гадаргын өндөр

- 700-1000м
- 1000-1500м
- 1500-2000м
- 2000-3000м
- > 3000м

Суурьшил

- Аймгийн төв
- Сумын төв
- Байнгын горимтой хилийн боомт
- Түр ажиллагаатай хилийн боомт

Зам тээвэр

- Хатуу хучилттай авто зам
- Шороон зам
- ✈ Орон нутгийн чанартай нисэх буудал
- Засаг захиргааны хил хязгаар
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил

Logos: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ, ADB, Japan Fund for Poverty Reduction

Text: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН

Scale: 0 40km


Compass: N

Date: 2022 оны 3 дугаар сар

БАЙГАЛЬ ОРЧИН


УС

Усны нөөц (сая м3/ жил)



УУР АМЬСГАЛ

Жилийн дундаж хур тунадас (мм/жил)



ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ



Увс аймгийн нутаг дэвсгэрийн

%23,4

нь тусгай хамгаалалттай газар нутаг (2020)



VS




Монгол улсын нутаг дэвсгэрийн

13,5%

нь тусгай хамгаалалттай газар нутаг (2020)




ГАЗРЫН ДОРЙТОЛ



- Усны нөөц хангалттай (аймгууд дунд 10 дугаарт ордог).
- Байгалийн 3 үндсэн бүс, бүслүүрийг дамнан оршдог: ойт хээрийн бүс 10,7%, тал хээрийн бүс 25,6%, цөлөрхөг хээрийн бүс 50,5%.
- Урт, хүйтэн өвөл, богино, халуун зун бүхий эх газрын эрч тэс уур амьсгалтай. Хур тунадасны хувьд хуурай бүс нутаг.
- Газрын доройтол: 2020 онд Увс аймгийн 19 сумаас 9 сумын газрын доройтол ноцтой түвшинд хүрсэн байжээ. Үндсэн шалтгаан нь бэлчээр талхлалт – малын тоонд хяналт тавьж, бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах шаардлагатай.
- Дархан цаазат газар 1, байгалийн цогцолборт газар 2, байгалийн нөөц газар 3 бий, эдгээр ТХГН л доройтолд өртөөгүй байна.

Эдийн засаг

ТАНИХ ТЭМДЭГ



Мал аж ахуй
 Малын тоо 265,900 Тэс

Газар тариалан (тонн, 2018)
 Төмс Тэжээл Хүнсний ногоо Үр тариа
 1573 5183 1355 17696

Эдийн засгийн гол салбарууд
 ХАА, хүнс барилгын материалын салбар
 г.м. салбар

Уул уурхай
 ▲ Давс
 ▲ Нүүрс
 ▲ Алт

Аялал жуулчлал
 Жуулчдын сонирхлыг ихээр татдаг газрууд
 1 Увс Нуур
 2 Хяргас нуур
 Жуулчдын сонирхлыг татдаг газрууд
 3 Хэцүү хад
 4 Хархираа, Түргэний уулс
 5 Үүрэг нуур



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
 АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
 ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН




ЭДИЙН ЗАСАГ

ДНБ-ийн дэлгэрэнгүй бүтэц



- Улсын ДНБ-ийн 1,2 хувийг бүрдүүлж, аймгууд дунд 13 дугаарт ордог.
- Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас хэт хамааралтай
- Үндсэн салбарын дотор тэнцвэрт байдал алдагдсан, мал аж ахуйн үйл ажиллагаа нь газар тариалангаас ихээр давамгайлдаг
- Үйлчилгээний салбар, үүнд аялал жуулчлал, мөн боловсруулах аж үйлдвэрлэл хөгжиж байна.

Хөдөлмөр эрхлэлт



Увс аймгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт хөдөө аж ахуйн салбарт ихээр төвлөрч (48%), түүний дараагаар бөөний ба жижиглэнгийн худалдаа (13%), боловсруулах үйлдвэрлэл (7,5%), боловсролын салбарт (7%) ногдож байна. Хөдөө аж ахуйн салбар аймгийн ДНБ-ийн 44 хувийг бүрдүүлдэг, эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай.

Эдийн засгийн үйл ажиллагаа

Увс аймгийн эдийн засгийн статистик мэдээг харвал бусад аймагтай харьцуулахад хүний сонирхлыг татах чадвар бага байна. Аймгийн эдийн засгийн эрчим (уул уурхайг эс тооцсон ДНБ-ийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваан гаргадаг) аймгуудын дундаж орчимд, бага зэрэг өсөлттэй байна. Үндсэн салбар давамгайлж байгаа нь ерөнхийдөө эдийн засгийн боломж, төрөлжилт дутагдалтай байгааг илэрхийлнэ. Увс аймгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих 3 гол салбар нь:



Үндсэн салбар: Малын чанарыг сайжруулах, тогтвортой арга туршлагыг хөгжүүлэх, дотоодын болон олон улсын хэмжээнд зах зээлээ нээлттэй болгох.



Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар: Боловсруулах аж үйлдвэр болон олон улсын аялал жуулчлал чиглэлд хөгжлийн ирээдүйтэй алхмууд хийх.



БДЖУ-ийн хөгжил: Аж үйлдвэрийн кластерийг хөгжүүлэх болдог, орон нутгийн үйлдвэрлэлийн хөтөлбөр бэлтгэж, төлөвлөх.



Мал аж ахуй: Эдийн засгийн үндсэн салбар боловч малын тоог хяналтгүй өсгөж байна

Мал аж ахуй бол хөдөлмөр эрхлэлт болон үйлдвэрлэлийн үндсэн салбар. Өнөөгийн байдлаар дараах 3 гол сорилттой тулгарч байна. Үүнд:

- Байгаль орчны тогтвортой байдал
- Зах зээл хүрэх
- Иргэд, олон нийтийн байгууллага. Түүнчлэн, малын тоо их учир бэлчээр талхлалт, бэлчээрийн доройтолд хүргэж байна. Эдийн засгийн өсөлтийг хангах Увс аймгийн чадавхад үндэслэн малын чанарыг сайжруулах, хөдөө аж ахуйг тогтвортой арга туршлагаар эрхлэх, зах зээлийг хөгжүүлэх боломжтой.

Хүн амын суурьшил

ТАНИХ ТЭМДЭГ



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН




2022 оны 3 дугаар сар

ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШИЛ

Хот, суурин – хүн ам (2020 он)

	Сумын хүн ам (2020)	Сумын төвийн хүн ам (2020)		Сумын хүн ам (2020)	Сумын төвийн хүн ам (2020)
Улаангом	32 407	31 279	Өмнеговь	4719	1014
Баруунтуруун	2765	1722	Өндөрхангай	3219	901
Бөхмөрөн	2294	893	Сагил	2483	778
Давст	1597	611	Тариалан	4011	1552
Завхан	1877	835	Түргэн	2078	670
Зүүнговь	2894	967	Тэс	5181	856
Зүүнхангай	2391	636	Ховд	2530	937
Малчин	2458	663	Хяргас	2558	864
Наранбулаг	4352	1145	Цагаанхайрхан	2071	888
Өлгий	2454	529			
Увс	84 294	47 740			


Шилжилт хөдөлгөөн



1990-2018 онд хүн ам шилжин явах үзэгдэл Увс аймагт хүчтэй явагдсан, энэ үзүүлэлтээр улсын хэмжээнд дээгүүр орно. Гэхдээ 2018 оноос хойш нөхцөл байдал эрс дээрдэж, хүн амын тоо шилжин явагсад бага байсан үеийнхтэй ижил болсон.

Улаангом хот: 32 407 хүн амтай, улсад 11 дүгээрт ордог

Орон зайн тэлэлт




Улаангом хот аймгийнхаа гол хот, суурины төв бөгөөд бусад сумаас хамаагүй их хүн амтай. 2005-2017 онд Улаангом хотын хүн ам 7500 хүнээр өсөж, хотын хилийн цэс хойшоо 120 га-аар тэлж, барилгажсан хэсгийн нягтрал нэмэгджээ. Орон сууцны хөгжлийн хувьд Улаангом хот аймгийн төвүүдийн дунджаас хамаагүй дээгүүр, хотын хойд хэсэгт бүх төрлийн үйлчилгээ дутагдалтай. Иймд тэнд үндсэн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх нь зүйтэй.

Орон сууцны хөгжил



Дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ

ТАНИХ ТЭМДЭГ



Эрүүл мэндийн үйлчилгээ

- Нэгдсэн эмнэлэг
- Сум дундын эрүүл мэндийн төв
- Сумын эрүүл мэндийн төв

Боловсролын хамгийн дээд түвшин

- Их дээд сургууль
- МСҮТ
- 12 жилийн сургууль
- 9 жилийн сургууль

Зам тээвэр

- Хатуу хучилттай авто зам
- Шороон зам
- Орон нутгийн чанартай нисэх буудал



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН



2022 оны 3 дугаар сар



ДЭД БҮТЭЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

Хотын үйлчилгээ: боловсрол ба эрүүл мэнд

Хотын үйлчилгээ: боловсрол ба эрүүл мэнд

- 72 эрүүл мэндийн байгууллага
- 197 хүний эмч
- 601 эрүүл мэндийн ажилчидтай

Увс аймгийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас арай доогуур (улсын дунджаар 70,41 жил, Увс аймгийн дунджаар 70,29 жил).

Боловсролын үйлчилгээ:

- Цэцэрлэг (сумдад 34)
- Их сургууль (Хөдөлмөрийн дээд сургуулийн салбартай, 150 оюутан суралцаж байна)
- Аймгийн төвд МСҮТ-тэй (1971 оноос хойш хоёрдогч шатны боловсрол олгож байна)
- 30 бага сургуультай – сум бүрийн сургууль дотуур байртай

Гэхдээ хамран сургалтын хувь улсын дунджаас доогуур: дунд сургуулийн хамран сургалт 92% (улсын дунджаар 96,6%) байна.


Тээвэр

Увс аймаг зэргэлдээх аймгууд руу зам харилцаа сайтай, баруун талд байрлах Баян-Өлгий аймгаас бусад аймаг руу хатуу хучилттай замтай. Улсын чанартай 2 төв зам тус аймгаар явж өнгөрдөг. Үүнд:

- Баруунаас зүүн тийш, нийслэл Улаанбаатар хот руу явдаг зам
- Өмнөөс хойш, ОХУ руу явдаг зам.

Тус аймаг Боршоо хилийн боомтоор (олон улсын статустай боомт, дамжин өнгөрсөн зорчигчдын тоогоор 24 боомтоос 7 дугаарт орсон) ОХУ-тай холбогддог. Улаангом хот нисэх онгоцны буудалтай, нийслэл хот руу тогтмол нислэг үйлддэг.

Хотын дэд бүтэц ба орон сууц



Увс аймгийн үндсэн дэд бүтэц, үйлчилгээний хүртээмжийг улсын дундажтай харьцуулахад маш хязгаарлагдмал. Гэхдээ сүүлийн 4 жилд аймаг, сумын амьдрах нөхцөл сайжруулахад улсын болон орон нутгийн төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна.

Аймгийн хүн амын эрэлтэд нийцүүлэн Аймаг, сумын төвийн бүсчилсэн, ногоон, дасан зохицох чадвартай хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөс дэд бүтцийг (ус хангамж, бохир ус, цахилгаан, дулаан, үерийн далан) сайжруулах ажил хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн, аймгийн төвөөс алс хол оршдог, авто замын харилцаа муутай 2 сум буюу Тэс, Бөхмөрөн сумдад “Шинэ сум” хөтөлбөр хэрэгжинэ.



Эдийн засаг

- Үндсэн салбар хөдөө аж ахуй:
- 3,4 сая толгой малтай = аймгийн ДНБ-ийн 36%.
- 55 мянган га тариалангийн талбайтай, 50 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, 300 га талбайд чацарганын тариалангийн кластертай.
- Мах бэлтгэх 2 үйлдвэртэй, ИНБИУ, ОХУ, БНХАУ руу экспортлодог.
- Улаангом хотод 200 м2 өвлийн хүлэмжийн аж ахуйтай.

Бизнесийн дэд бүтэц ба нөөц:

- Нийслэл Улаанбаатар хотоос хатуу хучилттай замтай.
- Боршоо хилийн боомт Азийн хурдны замын чиглэл 4-т холбогдсон.
- Уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох боломжтой (ОХУ, БНХАУ руу).
- Улаангом хотод олон улсын нисэх онгоцны буудалтай, Хяргас нуур, Баруунтуруун, Бөхмөрөн сумдад нисдэг тэрэгний аэродромтой.
- Дотоодын аяллын чиглэл: байгалийн үзэсгэлэнт газрууд, олон ястны соёлын өв.
- Малын чанарыг сайжруулж байна (ноолуурын ямаа, Тэс адууны хэвшил, Баяд үүлдрийн хоньтой).
- Гар аргаар арвайн гурил үйлдвэрлэдэг.

Олон улсын төсөл ба хөрөнгө оруулалт:

- Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих АХБ -ны төсөл (9192MON).
- АХБ-ны АСТБХХОХ мал аж ахуйн салбарыг дэмжих.
- АХБ-ны Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх төсөл.
- ОХУ-ын БНТува, БНХакас, БНГалтай Улсуудтай худалдааг нэмэгдүүлэх.
- Том компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.

Байгаль орчин

- Хүний гар хүрээгүй, харьцангуй онгон зэрлэг байгальтай.
- Цоохор ирвэс, аргал угалз, янгир ямаа зэрэг ховордсон төрөл зүйлийн амьтдын өлгий нутаг.
- Тусгай хамгаалалттай газар нутаг 6 бий: Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 21,3 хувийг эзэлдэг, шувуу хамгаалах чухал газруудтай.
- Увс нуурыг НҮБ-ын соёлын өвийн байгууллага (UNESCO)-ын шим мандлын нөөц газрын жагсаалтад бүртгэсэн.
- Увс, Хяргас нуурын орчимд тогтвортой аялал жуулчлалын баазуудтай.
- Сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, усан цахилгаан) үйлдвэрлэх боломжтой.
- Мал аж ахуй, газар тариалангийн тогтвортой үйл ажиллагааг дэмждэг: АХБ-ны АСТБХХОХ-өөр мал аж ахуйн тогтвортой өртгийн сүлжээг хөгжүүлэх.
- Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.
- Шувуу ажиглах аялал хийгддэг.

Хот, суурин

- Нийслэл Улаанбаатар хот руу хатуу хучилттай замтай (Улаангом хотоос).
- Бөхмөрөн сум сумын хөгжлөөр нэгдүгээрт ордог.
- Сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөтэй (Өндөрхангай, Тэс сумд).
- Байгалийн нөөц ба үйлдвэрлэл: эсгий, ургамлын цай, зэрлэг чацаргана, зөгийн аж ахуйтай.
- Уул уурхай: давс, бикарбонат сод, нүүрс, төмөр (Наранбулаг, Бөхмөрөн, Тэс сумд) олборлодог.
- Аялал жуулчлал: Наранбулаг, Улаангом.
- ОХУ, БНХАУ-тай хилийн харилцаа сайн.

Дэд бүтэц:

- Баруунтуруун: бага хэмжээний услалтын системтэй.
- Тэс: ус хангамж, бохирын ариутгах систем, цэвэрлэх байгууламж, дулаан хангамжийн систем.
- Улаангом: Цэвэрлэх байгууламж, дулааны систем, нийслэл хот руу хатуу хучилттай авто замын харилцаа, АХБ-ны АСТБХХОХ-өөр шинэ дэд бүтэц баригдах.

Нийгмийн хөгжил

- Ард иргэд нь ажилч хичээнгүй, бизнесийн сэтгэлгээтэй.
- Олон угсаатан бүлгийн хүмүүс амьдран суудаг.
- Албан бус, өрхийн бизнес: өрх, орон нутгийн эдийн засаг нэмэгдсэн.
- Хүн ам өсөж байна.
- Тэс сумын ус хангамж, дулаан, бохирын систем, цэвэрлэх байгууламж бусад суманд нэвтрүүлж болох сайн туршлага.
- Хил хамгаалах ангитай, нэмэлт ажиллах хүч байна гэсэн үг.

Орон нутгийн захиргаа

- Хамтарсан арга хэмжээнд орон нутгийн захиргааны ажилтнууд сайн оролцох чадвартай.
- Аймгийн захиргаанаас иргэдийн амьжиргааг сайжруулах үүрэг хариуцлага хүлээн ажилладаг.
- Хөдөлмөрийн дээд сургуультай (Монголын Үйлдвэрчний эвлэлийн харьяа), бэлтгэгдсэн хүний нөөцөөр хангадаг.
- Орон нутгийн захиргаанд залуу мэргэжилтнүүд, ахмад туршлагатай, төрийн албан хаагчид холилдон ажилладаг.

Эрүүл мэнд ба боловсрол

- Хүний эмч, багш нар хангалттай.
- Баруунтуруун сумын сургалтын чанар сайн.
- Тэс сум: 2 баг нь сургууль, эмнэлэгтэй, үйлчилгээг малчдад илүү хүргэдэг.
- Тэс сумын сургууль 6 настай хүүхдүүдэд зориулан гэртээ байгаа мэт орчин бүрдүүлсэн нь сайн туршлагатай.
- Хүүхдийн хөгжлийн дэд хөтөлбөртэй.
- ДЭМБ-ын явуулын эрүүл мэндийн үйлчилгээний төсөл хэрэгжсэн.

Эдийн засаг

- БАХ байгуулах ажил амжилттай болоогүй - малын гаралтай бүтээгдэхүүн борлуулах малчдын хоршоо байгуулах.
- Хүнсний ногооны үр үйлдвэрлэх багаж, төхөөрөмж дутагдалтай.
- Инженерийн хийцтэй услалтын систем байхгүй.
- ХАА-н бизнес эрхлэхэд дэд бүтцийн хөгжил (цахилгаан, хатуу хучилттай зам) сул.
- Баруунтуруун сум – гурил, тэжээлийн үйлдвэрлэл байхгүй болсон.
- Наранбулаг сум – арьс, шир боловсруулах шаардлагатай байгууламж байхгүй учир үйлдвэр ажиллахгүй байна.
- ЖДҮ-ийг хөгжүүлэх төлөвлөгөө байхгүй.
- ХАА-н бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөө байхгүй.
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө байхгүй.
- ХАА, аялал жуулчлалын салбарт туршлагатай ажиллагсад дутагдалтай.
- Жижиг бизнесүүдэд зориулсан санхүүжилт дутагдалтай.
- Малын тоо өсөж, бэлчээр доройтох шалтгаан болж байна.
- Хүнсний ногооны үр үйлдвэрлэх, чацаргана тариалах сургагдсан тариаланчид дутагдалтай.

ЭРСДЭЛ

- Хөрш зэргэлдээ улсуудтай улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөх.
- COVID-19 халдварын хязгаарлалт.

Байгаль орчин

- Малын тоог бууруулах, чанарыг сайжруулах бодлого эрчимтэй хэрэгжүүлдэггүй.
- Эмзэг эко системтэй.
- Аймгийн нутаг дэвсгэрийн 50,5% = хатуу ширүүн уур амьсгалтай заримдаг цөлийн бүс.
- Усны нөөц харьцангуй ховор (гадаргын усны нөөцөөр аймгууд дунд 10 дугаарт, газрын доорх усны нөөцөөр 11 дүгээрт ордог).
- Үйлдвэрлэлийн үйл явц тогтворгүй: малын тоо өсөж, бэлчээрийн даац хэтэрсэн, бэлчээрийг өрсөлдөж хэрэглэдэг, эмзэг эко системд уул уурхайн олборлолт хийдэг.
- Зун хэт их шумуултай болж, сумаараа нүүдэг. (Бөхмөрөн сум)
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах тухай өнөөгийн хууль, тогтоомж хөгжлийн шинэ бодлогод саад болж байна.

ЭРСДЭЛ

- Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал.
- Өндөр уулсын мөстлөг хайлах явц хурдсах.
- Гэнэтийн үерийн эрсдэл нэмэгдэх.
- Газар хөдлөх.

Хот, суурин

- Хог хаягдлын менежмент ба бохирын систем.
- Баруунтуруун, бусад сумдад төлөвлөгөөгүй, эмх замбараагүй газар олгож, хөгжилд саад болох.
- ОХУ-аас цахилгааны хамааралтай.
- Залуу үеийнхэн амралт, чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газаргүй.
- Дэд бүтцийн хөгжил сул: Баруунтуруун зам руу зам харилцаа муу, Наранбулаг сум бүхэлдээ нүхэн жорлон ашигладаг, Бөхмөрөн сум цэвэрлэх байгууламжгүй.

ЭРСДЭЛ

- Уур амьсгалын өөрчлөлт.
- COVID-19 халдварын хязгаарлалт.
- Орон нутгийн улс төрийн нөхцөл байдал.
- Хөрш улсуудын улс төрийн нөхцөл байдал.
- Хот суурины үер.
- ОХУ-аас цахилгааны хамааралтай байдал.

Нийгмийн хөгжил

- Ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр.
- Ихэнх сумын бохирын систем муу.
- Бөхмөрөн сум: сургуулийн барилга хуучирсан, шинэчлэх шаардлагатай.
- Оюуны бэрхшээлтэй хүмүүс олширч байна.
- Чацарганы тариаланд пестицид цацахад хүүхдүүд ажиллуулдаг.
- Давсны хэрэглээ улсын дунджаас өндөр – хоол боловсруулах, зүрс судасны системийн өвчлөл их.

ЭРСДЭЛ


- 6 настай хүүхдүүд сургуульд орох болсноос нийгмийн нөлөөлөл бий болсон.
- Малчид хятад мотоцикль унах дүрэм журам, практик сургалт дутагдалтай.
- Бөхмөрөн, Өмнөговь сумдад нүүрс, алт гар аргаар олборлож байна.
- Зам харилцаатай болсноос замын ойролцоо суурин газруудад осол аваар гарах эрсдэл, малчид мөрийтэй тоглоом тоглох нь ихэссэн.



Алсын хараа
Хөгжил ба уламжлалын зохицлыг
олох

Хот суурины тогтолцоо

ТАНИХ ТЭМДЭГ



Хот суурины тогтолцоо
Эдийн засгийн төв, нийгмийн үйлчилгээ авах сум дундын төв
Хөдөөгийн төв 1



- Нутаг дэвсгэрийн холбоо
- Аймгийн төв
- Сумын төв



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН



2022 оны 3 дугаар сар

ХОТ СУУРИНЫ ТОГТОЛЦОО

Өнөөгийн байдлаар Увс аймгийн хот суурины тогтолцоо аймгийн төв Улаангом хотод төвлөрч, аймгийн нийт хүн амын 40% оршин сууж байна. Баруунтуруун сум нэг томоохон төв байсан боловч сумын хүн ам буурч, өнөөдөр 17000 хүн оршин суудаг болжээ. Гэсэн хэдий боловч аймагтаа хоёрдох том хот хэвээрээ байна. Мянгаас дээш хүн амтай бусад хот, суурины төв нь Тариалан, Наранбулаг, Өмнөговь сумын төвүүд.

Бид Увс аймгийн 83617 иргэний хэрэгцээг хангах, амьжиргааг сайжруулах боломжтой хот суурины тогтолцоог Улаангом, Баруунтуруун, Өмнөговь сумын төвүүдэд түшиглэн байгуулах санал гаргаж байна. Аймгийн төв Улаангом хот гол хотын үүрэг, Баруунтуруун, Өмнөговь сумд сум дундын төвийн үүрэг гүйцэтгэж, төвөөс алс сумдад үйлчилгээ хүргэнэ гэсэн үг юм. Сум дундын төвүүдэд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах, мөн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгтэй. Дэд бүтцийн хөгжлийг АХБ-ны санхүүжилттэй АСТБХХОХ-ээс дэмжинэ.

Аймгийн төв **Улаангом хот** - **51077** хүнд үйлчилнэ

- Бусад сумаас хамаагүй их хүн амтай (31279), хүн ам өсөж буй
- Тохиромжтой дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгцээтэй.
- Хөгжлийн боломж: Мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих боловсруулах үйлдвэр барих.
- Улаангом хотыг хөгжүүлэхдээ дагуул хот болох Тариалан, Түргэн сумдыг хамруулах.
- Улаангом хотод түшиглэн хөгжүүлэх хот суурины тогтолцоо нь аймгийн баруун хойд хэсгийн Сагил, Бөхмөрөн, Давст, Наранбулаг, Малчин сумдад үйлчилгээ үзүүлнэ.



Баруунтуруун сум дундын төв - **21071** хүнд үйлчилнэ


- Хүн амын тоогоор аймагтаа хоёрдох том хот.
- Төрийн үйлчилгээ, дэд бүтэц арай илүү хөгжсөн ганцхан сумын төв.
- Аймгийнхаа баруун талд, газар зүйн хувьд мал аж ахуйгаар төрөлжсөн баруун талын сумдын төв нь болон оршдог.
- Хөгжлийн боломж: Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эд, бүтээгдэхүүнийг цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг сайжруулах.
- Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Хяргас, Зүүнговь, Тэс сумдад үйлчилгээ үзүүлнэ.

Өмнөговь сум дундын төв - **11649** хүнд үйлчилнэ

- Аймгийн өмнө талын сумдын төв.
- Зэргэлдээх сумдын тээврийн төв, мөн мал аж ахуйн худалдааны төв.
- Эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй.
- Завхан, Өлгий, Ховд сумдад үйлчилгээ үзүүлнэ.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн хөтөлбөр

ТАНИХ ТЭМДЭГ



- Хөдөө аж ахуйн хөгжил
- Газар тариалан эрхэлхэд тэргүүлэх газар
 - Бэлчээрийн менежментийн хөтөлбөр хэрэгжүүлэх тэргүүлэх сум
 - Тусгай хамгаалалтай газар
- Зам
- Шинэ хатуу хучилттай авто зам
 - Замын сүлжээг сайжруулах
- Хотын бүтэц
- Аймгийн төв
 - Дунд зэрэглэлийн хот
 - Хөдөөгийн төв
- Улаангом
- ХАА, хүнс, МАА-н дайвар бүтээгдэхүүн боловсруулах
 - Логистик/Тээврийн төв
- Дунд шатны хот сууринг бэхжүүлэх
- Хотын дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, орон сууцныг сайжруулах
 - МАА, газар тариалангийн чиглэлээр Агро-Парк хөгжих
 - Усжуулалтын систем
 - Аялал жуулчлал
- Бусад
- Ашигт малтмалын нөөц



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК
ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЯПОНЫ САН



2022 оны 3 дугаар сар

НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Увс аймгийн нийгэм, эдийн засаг, нутаг дэвсгэрийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьжиргааг сайжруулах үүднээс дараах төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

Хот байгуулалтын хөтөлбөр

Нутаг дэвсгэрийн хөгжлийн үзэл баримтлалаар том, жижиг хотууд нь:

1. Хөдөө аж ахуйн эдийн засгийг дэмжих үйлчилгээ, дэд бүтэц, зохион байгуулалтаар хангах
2. Нийгмийн үндсэн үйлчилгээ үзүүлэх
3. Иргэд амьдран суухад тааламжтай хотын орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

Энэ 3 зорилгоор аймгийн төв Улаангом хот, сум дундын төв Өмнөговь, Баруунтуруун сумдад үндсэндээ дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэн, хот байгуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Улаангом хотын хөнгөн үйлдвэрийн хөгжил

Аймгийн гол өртгийн сүлжээг хөгжүүлэн, цагаан ултай гутал зэрэг ирээдүйтэй үйлдвэрлэлийг дэмжих замаар хөнгөн үйлдвэрийг дэмжих. Мөн АХБ-ны АСТБХХОХ-өөс үйлдвэр, технологийн парк (ҮТП) байгуулахад дэмжлэг үзүүлэх.



Авто замын харилцааг сайжруулах

Энд 2 үндсэн асуудлыг дурдах нь зүйтэй. Үүнд:

1. Улаангом хотоос Баян-Өлгий аймаг руу буюу Өмнөговь сумаас Өлгий хот руу хатуу хучилттай авто зам барих, Баруунтуруун сумыг баруунаас зүүн чиглэлийн төв замд холбох
2. Орон нутгийн нутаг дэвсгэрийн холбоосын дагуу, өөрөөр хэлбэл аймгийн төв, сум дундын төвөөс зэргэлдээх сумын төвүүд рүү явдаг шороон замыг сайжруулах


Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах

Баруунтуруун, Тариалан, Өмнөговь сумдад тэжээл үйлдвэрлэлийг дэмжих, газар тариаланг хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор услалтын систем барих, засварлах төслүүд бэлтгэгдэж байна.

Мал аж ахуйн хөтөлбөр

Увс аймгийн эдийн засагт мал аж ахуй давамгайлдаг боловч тус аймаг хотын болон экспортын зах зээлээс хол оршдог. Одоо байгаа дэд бүтэц болон олон малтай байгаа нөхцөлд түшиглэн, малын ашиг шим, чанарыг сайжруулах шаардлагатай. Ийм хөтөлбөрийн гол авч үзэх асуудал нь анхан шатны болон дараагийн шатны боловсруулах үйлдвэр байгуулах, мал аж ахуйн өртгийн сүлжээг сайжруулах асуудал юм.

Архипелаг (Archipelago) тогтолцоо



Хотын төрөл

- Хайпер метрополис хот
- Метрополис хот
- Хот суурин газар #1 (бүсийн үйлчилгээ үзүүлэх төв)
- Хот суурин газар #2 (хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэмжих суурин газар)
- Баянбүрд
- Хөдөөгийн үйлчилгээний төв #1 (сум дундын төв)
- Хөдөөгийн үйлчилгээний төв #2 (нийгмийн үйлчилгээний төв)

Нутаг дэвсгэрийн холбоос

- — — Хөгжлийн коридор
- — — Кластер хөгжүүлэлт
- - - - - Тээврийн коридор



Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн хөтөлбөр
 Аймгийн хөгжлийн чиг баримжаа
УВС АЙМГИЙН АТЛАС

